



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2006 оны 9 сарын 5 өдөр

Дугаар 428

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэргүүлэгчдийн 2006 оны 154 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийн асуудлыг хариуцан гүйцэтгэх Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг хариуцсан "Багачууд хүнс", Баянгол, Сонгинохайрхан дүүрэг хариуцсан "Асгат", Баянзүрх, Хан-Уул дүүрэг хариуцсан "Өсвөр үе хүнс" нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. "Багачууд хүнс", "Өсвөр үе хүнс", "Асгат" нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын дүрмийн хэрэгжилтэнд хяналт гавьж ажиллахыг Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2006 оны
9 дугаар сарын ...5... өдрийн 42 дугаар
захирамжийн хавсралт

“.....” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамж нийслэлийн өмчит үйлдвэрийн газарнь нийслэлийн өмчид үндэслэн байгуулагдсан аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.
- 1.2 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд Монгол улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.
- 1.3 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын зорилго нь Улаанбаатар хотын сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаажсан, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахад оршино.
- 1.4 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах бие даасан хуулийн этгээд мөн.
- 1.5 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь нь өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

**Хоёр. Удирдлага зохион байгуулалт, үүсгэн
байгуулагчийн эрх**

- 2.1 “.....” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.
- 2.2 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын орлогч, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.
- 2.3 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батлаж, бүтэц орон

- 2.4 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал нь байгууллагын дотоод журам, бүтэц, орон тоо, цалин, урамшууллын хэмжээг тогтоож мөрдүүлэх ба албан хаагчдыг томилж чөлөөлнө.
- 2.5 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж эзэмшинэ.
- 2.6 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлын эрх үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг энэхүү дүрэм болон Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах Контрактаар зохицуулна.

Гурав. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны эрх хэмжээ

- 3.1 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах тухай шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцож, компанийн тухай хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.
- 3.2 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь өөрийн нэрийн өмнөөс гадаад дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгө болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх түүнчлэн шүүх, арбитрайн байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцоно.
- 3.3 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.
- 3.4 Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулна.
- 3.5 Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулинд заасан журмыг баримтлана.
- 3.6 Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, баталгаажсан, бүтээгдэхүүнээр нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг хангах үүднээс гол нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрээс нь шууд нийлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.7 Стандартын шаардлага хангасан бусад нэрийн хүнсний бүтээгдэхүүн /импортоор авдаг/-ийг зах зээлийн боломжит үнээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад нийлүүлэх ба боловсролын бүх шатны байгууллагуудтай үйл ажиллагааны хүрээнд хамтарч ажиллана.
- 3.8 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь хүнс нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд, дүүргүүдийн Засаг дарга нартай гэрээ байгуулж, төлбөр тооцоог тухай бүрд нь барагдуулан ажиллах.

4
8

Дөрөв. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын удирдлага, түүний эрх үүрэг

- 4.1 Захирал нь дүрэм болон контрактаар тогтоож өгсөн эрх хэмжээний дотор нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 4.2 Захирал нь үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлэлцээрийг дээд газраас олгосон эрх хэмжээний дотор хийнэ.
- 4.3 Захирлын эдлэх эрх, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг Контрактад тусгана.
- 4.4 Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхийг хориглоно.
- 4.5 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын албан тушаалтан нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл хяналт

- 5.1 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай", хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.
- 5.2 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.
- 5.3 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.
- 5.4 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.
- 5.5 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах

181

- 6.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өргөн барьснаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.2 Татан буулгах тохиолдолд Томилогдсон комисс уг ажлыг эрхэлнэ.

Долоо. Хариуцлага

- 7.1 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал нь Контракт, хөдөлмөрийн дотоод журмыг зөрчвөл хуульд заасны дагуу сахилгын шийтгэлийг шийдвэр гаргаж ногдуулна.
- 7.2 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж, байгууллагадаа хохирол учруулсан бол өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.
- 7.3 Захирлын гаргасан үйлдэл нь хууль зөрчсөн, гэмт хэргийн шинжтэй гэж үзэх үндэслэл байвал эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулна.

Найм. Бусад

- 8.1 Энэхүү дүрэмд Нийслэлийн засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

400